



НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Ур чадвар дүгнэх ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, газрын хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.7, 6.8 дахь заалт, газрын даргын 2020 оны А/32 дугаар тушаал “Ажилтан, албан хаагчидын ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын 2022 оны 1 дүгээр улирлын ур чадварыг дүгнэх ажлын хэсгийн гишүүдийг хавсралт ёсоор баталсугай.

2. Ажлын хэсэг ажилтан, албан хаагчдын ур чадварыг холбогдох дүрэм, журмын дагуу дүгнэж, дүнг 2022 оны 04 дүгээр сарын 9-ний өдрийн дотор газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Одончимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.Дэлгэр

Л.ДЭЛГЭР



1150500035

Нийтлэг үйлчилгээний газрын даргын
2022 оны 03 дугаар сарын 02-ний
өдрийн 03 дугаар тушаалын хавсралт

АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
УР ЧАДВАР ДҮГНЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

АХЛАГЧ :

Ш.Одончимэг
Орлогч дарга

ГИШҮҮД:

Л.Уранхайч
Үйлдвэрлэл, үйлчилгээний албаны
дарга

Л.Мөсчихэр
Инженерийн байгууламжийн ашиглалт,
үйлчилгээний албаны дарга

Г.Энхтуяа
Захиргааны ахлах мэргэжилтэн

НАРИЙН БИЧИГ:

Б.Хэнмэдэх
Дотоод хяналт хариуцсан ажилтан